

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

**Цахим орчны зохицуулалт, цахим  
тоглоомын насны ангилал**

**Б.Алтангэрэл  
Мэргэжилтэн  
Зохицуулалтын алба**

# Агуулга

1. Дэлхийн улс орнуудын цахим орчинд зохицуулалт хийж байгаа туршлага
2. Цахим орчны зохицуулалт - Монгол Улс
3. Цахим тоглоомын насны ангилал
4. Хэрэгжүүлж буй ажлууд

# Дэлхийн улс орнуудын цахим орчинд зохицуулалт хийж байгаа туршлага


- **Үндэсний аюулгүй байдал**  
(тэсэрч дэлбэрэх бодис үйлдвэрлэх зөвлөмж, хууль бус эмийн үйлдвэрлэл, алан хядах үйл ажиллагаа)
- **Хүүхдийг хамгаалах**  
(насанд хүрээгүй хүүхдийг хараалын үгс ашигласан маркетинг, хүчирхийлэл болон садар самуун үйл ажиллагаанаас хамгаалах)
- **Хувь хүний нэр төрийг хамгаалах**  
(арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, үзэн ядах буюу өдөөн турхирах)
- **Эдийн засгийн гэмт хэрэг**  
(мэхлэлт, кредит картын хулгай хийх заавар зэрэг)

# Дэлхийн улс орнуудын цахим орчинд зохицуулалт хийж байгаа туршлага

- **Мэдээллийн аюулгүй байдал**  
(бусдын мэдээллийг хууран мэхлэх замаар олж авах)
- **Хувийн нууцыг хамгаалах**  
(хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр түгээх, цахим харилцаагаар дамжуулан дарамтлах)
- **Бизнесийн нэр хүндийг хамгаалах**  
(гүтгэлэг, хууль бус харьцуулсан реклам)
- **Оюуны өмчийг хамгаалах**  
(програм хангамж, хөгжим зэрэг зохиогчийн эрхийн бүтээлийг зөвшөөрөлгүйгээр түгээх)

# Дэлхийн улс орнуудын цахим орчинд зохицуулалт хийж байгаа туршлага

Техникийн бус




Хууль

Журам, нөхцөл шаардлага

Тусгай зөвшөөрөл олгох

Техникийн




IP хаягийг блоклох

DNS шүүлтүүр

URL шүүлтүүр гм

# Дэлхийн улс орнуудын цахим орчинд зохицуулалт хийж байгаа туршлага



Маш өндөр зохицуулалттай:  
АНУ, ОХУ, Энэтхэг, Иран, БНСУ, Беларус ...

Өндөр зохицуулалттай:  
Тайланд, Малайз, Сингапур ...

Тодорхой хэмжээний зохицуулалттай:  
Казакистан, Мороко, Алжир, Колумб ...

Зохицуулалттай, нэмэгдэх хандлагатай  
Австрали, Франц, Тунис Израйл...


Бага зэрэг/зохицуулалтгүй:  
Канад, Европ болон Латин Америкийн ихэнх улсууд, Монгол, Япон ...

Мэдээлэл байхгүй



# Цахим орчны зохицуулалт - Монгол Улс

Монгол Улс



Техникийн бус – “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”

Техникийн – DNS шүүлтүүр

# Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага

Веб сайтын үйлчилгээ эрхлэгчдэд:

- Холбогдох хаяг мэдээллийг нүүр хуудсанд ил харагдахуйц байрлуулах
- Веб сайтын үйлчилгээ эрхлэгч нь насан хүрэгчдэд зориулсан контентээр үйлчлэхдээ хэрэглэгчдэд 18-аас дээш насныханд зориулсныг урьдчилан сануулж, бүртгэл хийж, бүртгэсэн нэр нууц үгээр хандалт хийлгэнэ
- Хэрэглэгчийг хандах үед ямар нэгэн анхааруулга, зөвшөөрөл авалгүйгээр өөрийн сайтын фейсбүүк хуудас дээр автоматаар “LIKE” даруулахыг хориглоно





# Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага

## СУРАГЧДЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ,ИНТЕРНЕТИЙН ОРЧИНД АЖИЛЛАХ ЖУРМЫГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА



Ухаалаг гар утас, нөүтбүүк, таблет, зурагт гэх зэрэг орчин үеийн техник технологи маш хурдтай хөгжиж, интернет, facebook, twitter, instagram зэрэг нийгмийн харилцааны сүвгүүд бид бүхний өдөр тутмын амьдралын зайлшгүй хэрэглээний нэг болжээ. Одоо эдгээр нь зөвхөн томчууд гэлтгүй бага насны хүүхдүүдийн өргөн хэрэглээнд шилжиж байна.



Энэ хэрэглээ нь өнөө цаг үеийн гол хэрэглээ мөн гэдэгтэй хэн ч маргахгүй үнэн.Гэхдээ хүн төрөлхтөний бий болгосон зүйл,нээлт, ололт, амжилт хэдий ч эргээд хэрэглэгч эзэндээ үзүүлэх сөрөг нөлөө,хор уршиг нь их байдаг.Энэ хорвоод үнэгүй зүйл гэж байдаггүй.Танд хялбар амар зугаацуулах мэдрэмжүүдийг өгдөг хэдий ч таниас авах зүйл нь хамгийн үнэтэй зүйл болон хувирч байгааг ч дэлхийн эрүүл мэндийн байгууллагууд анхааруулсаар байна.Мөн Монголын Харилцаа Холбооны зохицуулах хорооноос гаргасан зөвлөмж,УИХ-д орохоор өргөн баригдсан хуулийн төсөл,боловсрол хөгжсөн гадаадын улс орнуудын туршилгыг судлан үзэж дараах шийдвэрийг гаргаж байна.



Оюунлаг бүрэн дунд сургуулийн захирлын тушаал гарч,сургуулийн дүрэм болон дотоод журманд гар утасны хэрэглээ,интернет орчинд ажиллах журмыг боловсруулан холбогдох заалтуудыг нэмэлтээр оруулан

2015 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх болсныг сонордуулж байна.



МАТЕМАТИК МЭДЭЭЛЭЛ ЗҮЙ  
ГАДААД ХЭЛНИЙ ГҮНЭГИЙРҮҮЛСЭН  
СУРГАЛТАЙ ОЮУНЛАГ БҮРЭН  
ДУНД СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

Гар утас,интернетиин хэрэглээний талаар авах арга хэмжээ

Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан, 2011оны 3-р сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж буй "Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага"-ын дагуу хэрэглэгч хүүхдүүдийн асуулгүй байдлыг хангах заалтууд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас сүүлийн үед өгч байгаа зөвлөмжийн санааг үндэслэн ТУШААХ НЬ

- 1.Гар утасны хэрэглээ нийгмийн хоорондын харилцааны хэрэггүй болсон интернетийн орчин дахь facebook, twitter, instagram-ын зохистой хэрэглээг бий болгохын тулд сургуулийн орчинд дагаж мөрдөх журмыг шинээр боловсруулан 2015 оны 03 сарын 01-нээс эхлэн мөрдөж ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Уянзоригт үүрэг болгосугай.
- 2.Энэхүү шинэ журмыг сургалт хүүхдүүдийн харилцаанд оролцож байгаа багш,сурагч, эцэг эхчүүд, хамтран ажилладаг байгууллагуудад сурталчилан таниуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг тэмцлийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.
- 3.Тушаалын хэрэгжилтийг хангах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиглахыг ерөнхий менежер Ч.Цэцэгээд зөвшөөрсугэй.

## БАТЛАВ.СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ 2014 оны 12 сарын 20-ны өдөр ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ,ИНТЕРНЕТИЙН ОРЧИНД АЖИЛЛАХ ЖУРАМ

Энэхүү журмыг тус сургуулийн нийт сурагчид, багш сурган хүмүүжүүлэгчид, ажилтан ажиллагсад, эцэг эхчүүд,бидэнтэй хамтран ажилладаг байгууллагууд хүндэтгэлтэй хандан дагаж мөрдөнө.

**Зорилго** Харилцаа холбооны шинэ эрин үеийн техник технологийн эерэг ба сөрөг хүчин зүйлийг нийтэд сурталчилан таниулах,ухаалаг гар утасны зүй зохистой хэрэглээг бий болгох, интернетийн орчны сөрөг нөлөөллөөс хамгаалах,зохисгүй хэрэглээний эрсдлийг бууруулах,хичээл сургалтанд сурагчдын хандах хандлага оролцоог идэвхижүүлэхэд оршино.

### Нэг.Сурагчийн эрх ,үүрэг

- 1.Бага ангийн сурагчид (1-5-р анги) сургуулийн орчинд ямарваа нэгэн гар утас хэрэглэх, тавлет,компьютер ашиглахыг хориглоно.
- 2.Бага ангийн сурагчид аав ээжийнхээ зөвшөөрснөөр гэртээ зурагтын нэвтрүүлгийг өдөрт 45 минутаас 1цаг 20 минутаас илүүгүйгээр үзэж болохыг зөвлөж байна. Харин компьютер ухаалаг гар утас ашиглан 40 минутаас илүү ашиглахгүй байхыг сануулж байна.
- 3.Дунд болон ахлах (6-12-р анги) ангийн сурагчид андройд,Iphone,Tablet зэрэг гар утсыг хэрэглэж болох ба хичээл сургалттай өдрүүдэд өглөөний 8цаг 30 минутаас үдээс хойшийн 15цаг 30 минут хүртэл бүрэн унтрааж, ил гаргахгүй байх үүрэгтэй.
- 4.Компьютерийн лаборатори болон хичээл сургалтын үед багшийн зөвшөөрөл, хяналттайгаар интернет орчинг ашиглан notebook,tablet ашиглах эрх үүсч болно.

- 5.Дунд ахлах ангийн сурагчид зурагт үзэх болон интернетийн орчинд орох нийт хугацааг өдөрт 3 цагаас илүү ашиглахгүй байх нь зүйтэй.
- 6.Гар утасны бүрэн бүтэн байдал,алдагдах хаяж гээгдэхтэй холбоотой асуудлыг сурагч өөрөө бүрэн хариуцна.
- 7.Уулзалт,үзвэр,үйлчилгээ,сургалт дадлага болон цайны газар,урлагийн танхим, номын сан зэрэг танхмуудад олон нийтийн арга хэмжээн зохион байгуулагдаж байгаа үед гар утсаа бүрэн унтраасан байх үүрэгтэй.
- 8.Гар утасны хэрэглээний соёл ,ёс зүйг эрхэмлэн багш,эцэг эхийн зөвөлгөө, сануулгыг өөртөө эерэг байдлаар тусган өдөр тутам анхаарч байх.

### Хоёр. Цэг эхийн эрх үүрэг

- 1.Хүүхдүүддээ хандсан гар утасны хэрэглээ,зурагт үзэх цаг хугацааг өдрийн дэглэм гарган мөрдүүлэх, интернет, facebook, twitter, instagram ашиглалтын талаар хэлэлцэн тохиролцож зүй зохистой хэрэглээнд сургахад анхаарч зөвлөж байх үүрэгтэй.
- 2.Хичээл сургалтын үед хүүхэдтэйгээ гар утсаар холбоо барихгүй байх.Хүндэтгэн үзэх шалтгаантай бол анги удирдсан багшаар дамжуулан ярьж болно.
- 3.Хүүхдэддээ бэлэн мөнгө өгч явуулах,анхаарал халамжаа сулруулснаас хүүхэд интернет тоглоомыг донтох,олон цагаар интернетийн зохисгүй хэрэглээнд орох эрсдэлтэй байдаг анхаарч ажиллах.



# Цахим орчны зохицуулалт - Монгол Улс

“Интернетийн үйлчилгээ эрхлэх тусгай нөхцөл шаардлага”:



- 5.2 “Төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудад интернетийн үйлчилгээг үзүүлэх тохиолдолд насанд хүрэгчдэд зориулсан веб хуудсыг хаана”
- 5.3 “Айл өрхийн интернет, интернет кафе 18-аас дээш насны контентруу хандах хандалтыг хязгаарлах боломжийг бүрдүүлэх зорилгоор шүүлтүүртэй интернетийн санал болгоно” гэж тус тус зааж өгсөн

# Цахим тоглоомын насны ангилал



- Дэлхий дээр хүлээн зөвшөөрөгдсөн хэд хэдэн насны ангилал тогтоогч байгууллага байдаг бөгөөд тэдгээрээс хамгийн том нь ESRB болон PEGI нар юм. Эдгээр байгууллагууд нь бусдаас хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг.
- Канад болон АНУ-д гаргасан тоглоомнуудад хяналт тавьдаг байгууллага юм.
- Тоглоомын зах зээлийн хамгийн том худалдан авагч буюу үйлчлүүлэгчид нь АНУ-д байдаг тул энэ байгууллагаас үнэлгээ авалгүйгээр худалдаанд гарсан тоглоом огт байдаггүй

# Цахим тоглоомын насны ангилал



**Бага насныханд.** Энэ ангилалд 3 - 10 насны хүүхдүүд хамаарах бөгөөд 1994 оноос эхлэн мөрдөж эхлэсэн байна. 3 -с доош насны ангилалд багтсан тоглоомонд Сургалтын гэсэн үнэлгээ өгдөг бөгөөд тийм үнэлгээ авсан тоглоомонд тусгай тэмдэглэгээ хэрэгцээгүй байдаг байна. Энэ төрлийн тоглоомнууд нь ойлгомжтой өнгө дүрс нь хүүхдэд зориулагдсан байдаг бөгөөд тоглох хэлбэр нь ч мөн адил энгийн бяцхан хүүхдэд зориулагдсан байдаг. Мөн ямар нэг хүчирхийлэл, согтууруулах ундаа, мансууруулах эм бэлдмэл гэх мэт зүйлсийг огт агуулаагүй байдаг байна.



**Бүх насныханд.** Энэ ангилал нь бараг хамгийн түгээмэл байдаг бөгөөд 6-с дээш бүх насныханд тохиромжтой гэсэн утга агуулдаг. Энэ ангилалд багтсан тоглоомнууд дээрхийн адил ямар нэг хүчирхийлэл, ёс бус зүйл огт агуулдаггүй. Гэхдээ хүүхэлдэйн баатрууд, уран зөгнөл, маш бага хэмжээний хүчирхийлэл агуулдаг. Бага хэмжээний хүчирхийлэл гэдэг нь тоглоомны баатрууд эсрэг талынхнаа цохих дээр нь гарах гэх мэт. Энэ ангилалыг 1998 оноос мөрдөж эхэлжээ



**10-с дээш насныханд.** Энэ ангилал нь 10-с дээш насныханд буюу арай учир ойлгодог болсон хүүхдэд зориулсан юм. Энэ ангилалын тоглоомнууд бага хэмжээний хүчирхийлэл, уран зөгнөл, хиймэл цусны зураглал, ёс бус үг хэллэг зэргийг агуулдаг. Гэхдээ таны хүүхэд 10-с дээш насных бол ямар нэг хортой эсвэл буруу зуршил өгөх зүйл байхгүй. Энэ ангилалыг 2005 оноос эхлэн хэрэгжүүлсэн.



**Өсвөр насныханд зориулсан ангилал буюу 13 болон түүнээс дээш насныханд.**

Энэ төрлийн тоглоом нь дунд зэргийн хүчирхийлэл, бохир хошигнол, цус, хийсвэр мөрийтэй тоглоом, бага зэрэг ёс бус үг хэллэг агуулдаг. Гэхдээ энэ нь тийм их санаа зовохоор хэмжээнд биш бөгөөд 13 насны хүүхдүүд тоглоом гэдгийг ойлгохуйц болсон байдаг тул хор нөлөө үзүүлэх нь бага.



**17 болон түүнээс дээш насныханд.** Энэ ангилалд секс дүр төрх, цус, ёс бус үг хэллэг, согтууруулах ундаа зэрэг зүйлс агуулсан тоглоомнууд багтана. Хэрвээ энэ төрлийн тоглоомыг таны 17-с доош насны хүүхэд тоглохыг хүсвэл та хажууд нь байж хүүхдэд тоглоом гэдгийг ойлгуулж эдгээр зүйлсийн талаар зөв ойлголт өгөх хэрэгтэй. Харин эцэг эхийн зөвшөөрөл хараа хяналтгүйгээр энэ ангилалын тоглоомыг 17 -с доош насныханд тоглуулахгүй байх нь зөв юм.



**Зөвхөн насан хүрэгчдэд.** Ийм төрлийн тоглоомнуудыг дэлгүүрүүд хүүхдэд худалдаалах ёсгүй бөгөөд архи, тамхины адилаар зөвхөн насанд хүрэгчдэд л худалдаалах боломжтой. Энэ төрлийн тоглоомнууд нь хүчирхийлэл, секс, ёс бус үг хэллэгийг дээд хэмжээнд агуулах бөгөөд энэ ангилалд 2010 он хүртэл ердөө 25 тоглоом л багтсан юм.

# Хэрэгжүүлж буй ажлууд

[www.happywebs.mn](http://www.happywebs.mn)

- Холбогдох хууль, тогтоомжийг таниулах, сурталчлах
- Цахим хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон улсын туршлага, хөгжлийн чиг хандлагын талаар таниулах, сурталчлах
- Мэдээ, мэдээлэл хүргэх, соён гэгээрүүлэх
- Сайтын онлайн бүртгэл хийх
- Зохицуулагч байгууллага, сайт хоорондын хамтын ажиллагааг дэмжих

[www.cybersafety.mn](http://www.cybersafety.mn)

- ОУЦХБ-ын гишүүн байгууллагуудын санал санаачлагыг дэмжих
- Хүүхэд багачуудад цахим орчны соёлтой хэрэглээг төлөвшүүлэх
- Цахим тоглоомын насан ангилал, түүний зүй зохистой хэрэглээний талаар мэдээлэл хүргэх
- Хүүхэд багачууд, өсвөр насныхан, эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгчдэд цахим орчны аюулгүй байдал, зөв зохистой хэрэглээ, гарын авлагаар хангах



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

**Анхаарал тавьсанд  
баярлалаа!**